



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 534

Улаанбаатар хот

Үйлчилгээний автомашины тоо, төрөл
тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 5 дугаар заалт, Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар баталсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны үйл ажиллагааны онцлог, цар хүрээг харгалзан үндсэн үйл ажиллагаа, дотоод албан хэрэгцээнд ашиглах үйлчилгээний автомашины тоо, төрлийг хавсралтад зааснаар баталсугай.

2. Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үйлчилгээний автомашины ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах;

2.2. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журмын хэрэгжилтийг хангах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 11 дүгээр сарын 07-ны/ний өдрийн
554 дугаар тогтоолын хавсралт



СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДОТООД АЛБАН АЖЛЫН ХЭРЭГЦЭЭНД
АШИГЛАХ АВТОМАШИНЫ АНГИЛАЛ, ТОО, ТӨРӨЛ

Д/д	Үндсэн ангилал	Төрөл	Тоо
1	Үйлчилгээний автомашин	Ачааны ажлын автомашин (жижиг)	1
2		Хот доторх ажлын суудлын автомашин (жижиг)	1
3		Ажлын жижиг оврын автобус (микро автобус)	1
Нийт автомашин			3